

## I-V ангийн хэл зүй, үгсийн сангийн агуулгын залгамж холбоо

ХЭЛ ЗҮЙ, ҮГИЙН САН					
Хэл зүй	1.4а. Эгшиг, гийгүүлэгч, тэмдэг үгсийг ялган таних	2.4а. Хэн юу ямар хэд хэчнээн, яах, яав яасан гэсэн асуултад хариулагдах үгсийг олох, өгүүлбэр, эх зохиохдоо зөв хэрэглэх	3.4а. Эх өгүүлбэрээс хэн?, юу?, яав?, яаж?, яагаад?, ямар учраас? гэсэн асуултад хариулагдах үгсийг олох, хэрэглэх	4.4а. Харин, ийм учраас, цаашилбал, үүнээс гадна, яагаад гэвэл, үүнээс болж, ба, бөгөөд зэрэг холбох үгсийг хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох	5.4а. Эх, өгүүлбэр зохиохдоо хашилт, хаалт, цэг тэмдгийг зөв хэрэглэх
	1.4б. Эх, өгүүлбэр дэх үгсийг хэн? юу? яав? гэсэн асуултаар ялгах	2.4б. Асуусан, хүүрнэсэн өнгө аястай өгүүлбэр зохиохдоо асуултын тэмдэг, таслал, цэгийг оновчтой хэрэглэх	3.4б. Уншсан эхээс анхааруулах өгүүлбэрийг ялган таних, бичихдээ анхаарлын тэмдэг, таслал, цэгийг оновчтой хэрэглэх	4.4б. Уриалсан, зөвлөсөн өнгө аясыг илтгэх үг хэллэгийг оновчтой хэрэглэн, өгүүлбэр, эх зохиох	5.4б. Эх, өгүүлбэрт баталсан, дэмжсэн өнгө аясыг илтгэсэн үг, өгүүлбэрийг оновчтой хэрэглэх
Үгийн нөөц	1.4в. Өгүүлбэрийг 1-2 асуултаар дэлгэрүүлэх	"2.4в. Эсрэг утгатай үгийг таних, өгүүлбэр зохиохдоо хэрэглэх "	3.4в. Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох	4.4в. Ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэн өгүүлбэр, эх зохиох	5.4в. Эх, өгүүлбэр зохиохдоо ойролцоо утга, эсрэг утгатай үгийг найруулгад оновчтой хэрэглэх
		"2.4г. Халц үгийн тайлбарыг уншиж ойлгох, цээжилж тогтоох"	"3.4г. Халц үгийн тайлбарыг уншиж ойлгох, өгүүлбэр зохиохдоо хэрэглэх "	"4.4г. Эх, өгүүлбэр зохиохдоо халц үгийг утгаар нь зөв хэрэглэх"	"5.4г. Эх, өгүүлбэр зохиохдоо халц үгийг утгаар нь зөв хэрэглэх"



Сурагчийн нэр: .....

Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр.....цаг

	асуулт	жишээ
	хэн?	багш, Саран, ээж, өвгөн
	юу?	баавгай, цэцэг, мөндөр, онгоц
	ямар?	улаан, дугуй, түргэн, зузаан, цоглог, хөөрхөн
	хэд, хэчнээн?	хоёр, тав дахин, долуулаа, сая
	яах? яасан? яав? яадаг?	дэгдэх, суув, уншсан, давхидаг, цэцэглэв

1 Асуулт тавьсан үгийг ажиглаад, цэгийн оронд асуулт бичээрэй.

хэн? юу? яах? ямар? хэд? яадаг? .....?  
 Наран авдар бүжиглэх дөрвөлжин нэг зуу уншдаг аав

.....?  
 давхисан хоёулаа гоё гурвалжин бичих

2 Дараах үгсийг асуултаар ангилж бичээрэй.

“найзууд, том, дуулав, төмөр, Төмөр, гурав, бал, нагац, мөрөөдөв, цүнх, зургаа, ганц, ягаан, дөрвөлжин, тоглов”

<p>хэн?</p> <p>нагац, ..... .....</p>	<p>юу?</p> <p>бал, ..... .....</p>	<p>ямар?</p> <p>том, ..... .....</p>	<p>хэд?</p> <p>ганц, ..... .....</p>	<p>яав?</p> <p>тоглов, ..... .....</p>
---	--	--	--	--

3 Асуултад хариулагдах үг олж, өгүүлбэрийг гүйцээж зохиогоорой.

хэн?	яасан?	Хэдэн?	юу?	яав?
Намуун	дуулсан.	Зургаан	онгоц	нисэв.
Найзууд			баавгай	ирэв.
	уншсан.	Зуун		ургав.

Дууссан: .....он .....сар .....өдөр .....цаг

Өөрийн үнэлгээ:

1 2 3

## Хэн, юу, ямар, хэд, яах, яав, яасан гэсэн асуултад хариулагдах үгсийг олж



Сурагчийн нэр: ..... Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр.....цаг

1 Утга нь тохирох үгүүдийг холбоорой.

зузаан	<input type="radio"/>	эм	<input type="radio"/>	тарган	<input type="radio"/>	дэвтэр	<input type="radio"/>
алаг	<input type="radio"/>	шугам	<input type="radio"/>	нимгэн	<input type="radio"/>	мах	<input type="radio"/>
гурвалжин	<input type="radio"/>	цамц	<input type="radio"/>	том	<input type="radio"/>	сандал	<input type="radio"/>
гашуун	<input type="radio"/>	гөлөг	<input type="radio"/>	намхан	<input type="radio"/>	машин	<input type="radio"/>

2 Дээрх үгсээс дараах асуултад тохирох үг түүж бичээрэй

ямар?

юу?

3 Асуултад тохирох үг олж бичээрэй

ямар?	хэн?	хэдэн?
.....	.....	.....
.....	.....	.....
.....	.....	.....

машин      дуулав.      шувуу

4 Зургийг ажиглаад, асуултад хариулж бичээрэй

- Хэн хэн явж байна вэ? Хүүхдүүдэд нэр өгөөрэй.
- Хэдэн шувуу, хэдэн нохой байна вэ?




Handwriting practice lines for the answer to question 4.



Сурагчийн нэр: ..... Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр.....цаг



Асуусан өгүүлбэрийн эцэст асуултын тэмдэг (?)



Хүүрнэсэн өгүүлбэрийн эцэст цэг (.)



**Эвтэй дөрвөн амьтан**



Эрт цагт ойд тагтаа, туулай, сармагчин, заан дөрөв амьдардаг байжээ. Нэг өдөр бидний хамгийн ахмад нь ямар амьтан бэ? гэж бие биеэсээ асуужээ. Заан нэг том модыг зааж: – Намайг тугал байхад энэ мод надтай чацуу тул би шөргөөдөг байв гэжээ. Бич хэлэв: – Намайг жаахан байхад энэ мод дүүлэх мөчиргүй, надтай адилхан байсан тул сүүдэр нь намайг халхалдаггүй байсан гэв. Туулай хэлэв: – Намайг бага байхад мод сая үндэслэж байсан тул би үндэснээс нь малтаж иддэг байв гэжээ. Гэтэл тагтаа хэлэв: – Би энэ модны үрийг зууж ирээд энд унагачихсан. Тэгээд энэ мод ургасан билээ гэв. Ийм болохоор ахмад нь тагтаа, дүү нь туулай, туулайны дүү сармагчин отгон дүү нь заан болж таарч, түүнээс хойш ахмадаа хүндлэн амьдрах болжээ.

1 Эхээс хариулсан өгүүлбэрийг түүж бичээрэй

Хариулсан өгүүлбэр



Асуусан өгүүлбэр

Бидний хамгийн ахмад нь ямар амьтан бэ?

2 Аль тэмдгийг тавих вэ? Зөв харгалзуулаарай

Ахыгаа алд, дүүгээ дэлэм хүндэлдэг



асуух

Эвт шаазгай буга барьдаг юмуу



хүүрнэх



Сурагчийн нэр: ..... Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр.....цаг

3 Тохирох цэг, тэмдгийг тавьж, асуулт хариултыг зөв харгалзуулаарай

Асуулт	Хариулт
Заан модыг яадаг байсан бэ ( )	Туулай үндэс малтаж иддэг ( )
Мод сармагчинг халхалдаг байсан уу ( )	Тагтаа үрийг зууж авчирсан ( )
Туулай юу иддэг байсан бэ ( )	Сармагчинг мод халхалдаггүй ( )
Тагтаа үрийг яаж авчирсан бэ ( )	Заан модыг шөргөөдөг байсан ( )

4 Өгүүлбэрийн төгсгөлийг зөв харгалзуулаарай.

Хамгийн ах нь ямар амьтан	уу?
Сармагчин туулайнаас ах	үү?
Туулай тагтаанаас дүү	юу?
Тагтаа заанаас ах	бэ?
Хамгийн бага дүү нь туулай	юу?
Тэд алимаа идсэн	уу?

5 Хүүрнэх өгүүлбэрийг асуух өгүүлбэр болгоорой.

Хүн ахтай, дээл захтай гэдэг үг мэднэ.

*Хүн ахтай, дээл захтай гэдэг үг мэдэх үү?*

Ах нь сургаж, дүү нь сонсдог.

Эвт шаазгай буга барьдаг.



Сурагчийн нэр: ..... Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр.....цаг



Үгийн эрс өөр утга санааг илэрхийлэх үгийг эсрэг үг гэнэ. Жишээ нь: өндөр – нам, суух – босох, хар – цагаан, хаах – нээх, зөв - буруу

1 Эсрэг үйлдлийг холбоорой.

	нээх	0		сэрэх	0
	унтах	0		унтраах	0
	асаах	0		хаах	0

2 Зөв харгалзуулаад, дутуу үгийг нөхөж бичээрэй.

	зузаан	0		.....	0
	цэвэр	0		дүүрэн	0
	.....	0		.....	0
	.....	0		хөнгөн	0

3 Зургийг ажиглан, эсрэг утгатай үгийг бичээрэй.

<i>сүйтэн</i>					
<i>халуун</i>					



Сурагчийн нэр: ..... Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр.....цаг



Үгийн эрс өөр утга санааг илэрхийлэх үгийг эсрэг үг гэнэ. Жишээ нь: өндөр – нам, суух – босох, хар – цагаан, хаах – нээх, сайн - муу

1 Эсрэг утгатай үгийг ижил өнгөөр будаарай.

хуурай      хатуу      бүдүүн      зөөлөн

нам      **зөв**      өндөр

нойтон      нарийн      **буруу**

2 Эсрэг утгатай үгийг зөв бичээрэй.

зөв - .....



бүдүүн – .....



. богино – .....



3 Эсрэг утгатай үгийг оролцуулан өгүүлбэр зохиогоорой.



.....  
.....  
.....



.....  
.....  
.....



.....  
.....  
.....



Сурагчийн нэр: ..... Эхэлсэн: ..... он ..... сар ..... өдөр.....цаг



Үгс нийлэн, өөрийн утгыг алдаж, өөр нэгэн шинэ утга илэрхийлснийг хэлц үг гэнэ.

1 Эхийг уншаарай. Утгыг нь мэдэхгүй ямар үг байна вэ? Доогуур нь зураарай.

### Үнэгийг чадсан нь

Нэгэн өдөр ятуу ногоон дээр нүдний хор гаргахаар унтаад өгчээ. Тэгтэл түүгээр явсан үнэг “Өнөөдөр миний аз гийсэн өдөр байна. Тарган сайхан ятуу таарлаа” гээд өл дарахаар шийдэн, түүнийг зуугаад авчээ. Ятуу сэрж, үнэгний аманд орсноо мэдэв. Тэгээд үнэгт: - Өнөөдөр чи амны хишигтэй явна. Сайхан хоолтой боллоо. Чи бурхандаа залбир гэв. Үнэг “Би угаасаа азтай” гэж хэлэхээр амаа ангайхад нь ятуу дэрхийн нисэв. Ятуу амь гарсандаа магнайгаа хагартал баярлажээ.

Үнэг харин хууртсандаа гол нь харлаж, эргэж харалгүй алга болов.

2 Цэгийн оронд тохирох хэсгийг нөхөн бичээрэй..

Ятуу ногоон дээр .....

Үнэг ..... тулд түүнийг зуугаад авсан.

Ятуу: - Үнэг минь чи .....явна, залбир гэв

Үнэг сагсуурах гэж байж олзоо.....

Ятуу амь гараад ..... баярлажээ.

Үнэгт хууртсандаа ..... зугтан оджээ.





### Хэлц үгийн утгыг ойлгож, цээжилж тогтооё



3 Хэлц үгийн утгыг тайлбартай нь зөв харгалзуулаарай

нүдний хор гаргах	○	○	амьд үлдэх
өл дарах	○	○	хэсэг хугацаанд унтах
магнай хагарах	○	○	багахан идэх
амны хишиг	○	○	ихэд баярлах
амь гарах	○	○	харуусах
гол харлах	○	○	азтай, хийморьтой

4 Дээрх хэлц үгээс өгүүлбэрт тохирохыг нөхөж бичээрэй.

Би хөдөө явж, морь унах болсондоо ..... баярлав.

Handwriting practice lines for the first sentence.

Арга ухаанаар .....

Handwriting practice lines for the second sentence.

Аав ажлаа дуусгаад, ..... гээд хэвтлээ.

Handwriting practice lines for the third sentence.